



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/223


Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн аравнэгдүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141223848

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
...06 сарын 22 - ны өдрийн ...
А/223 дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Бүсгүй БГБХН-ийн эмнэлэг (Дотор, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ)	162/2023	3 жил	2023.07.04	2026.07.04
2.	Халиун толгой ХХК-ийн Халиун эмнэлэг	163/2023	3 жил	2023.07.04	2026.07.04
3.	Их шүүдэргэнэ импорт ХХК-ийн Медвик эмнэлэг	164/2023	1 жил	2023.06.21	2024.06.21
4.	Мөнгөт хайрхан оргил ХХК-ийн Ирээдүй эмнэлэг	165/2023	1 жил	2023.06.21	2024.06.21
5.	УАУЭСКТ-ийн дэргэдэх "Богдуул" сувилал	166/2023	2 жил	2023.06.24	2025.06.24
6.	Баянхонгор аймаг, "Ган зүү" эмнэлэг	167/2023	3 жил	2023.07.08	2026.07.08
7.	Сүхбаатар аймаг, "Эхэн ус" ХХК-ийн эмнэлэг	168/2023	2 жил	2023.07.01	2025.07.01
8.	Сэлэнгэ аймаг, Орхон сумын эрүүл мэндийн төв	169/2023	2 жил	2023.07.04	2025.07.04
9.	Сэлэнгэ аймаг, Орхонтуул сумын эрүүл мэндийн төв	170/2023	2 жил	2023.07.04	2025.07.04
10.	Сэлэнгэ аймаг, Рашаант сумын эрүүл мэндийн төв	171/2023	2 жил	2023.07.04	2025.07.04
11.	Сэлэнгэ аймаг, Номгон сумын эрүүл мэндийн төв	172/2023	2 жил	2023.07.04	2025.07.04
12.	Сэлэнгэ аймаг, Сант сумын эрүүл мэндийн төв	173/2023	3 жил	2023.07.08	2026.07.08
13.	Хэнтий аймаг, "Аврага тосон" рашаан сувилал	174/2023	2 жил	2023.06.21	2025.06.21
14.	Хэнтий аймаг, Батноров сумын эрүүл мэндийн төв	175/2023	3 жил	2023.07.08	2026.07.08
15.	Хөвсгөл аймаг, Хөвсгөл хүмүүн ХХК-ийн "Хүмүүн" эмнэлэг (Дотрын тусламж үйлчилгээ)	176/2023	3 жил	2023.07.08	2026.07.08
16.	Хөвсгөл аймаг, Бүрэнтогтох сумын эрүүл мэндийн төв	177/2023	3 жил	2023.06.24	2026.06.24
17.	Хөвсгөл аймаг, Жаргалант сумын эрүүл мэндийн төв	178/2023	2 жил	2023.06.24	2025.06.24
18.	Хөвсгөл аймаг, Хатгал сумын эрүүл мэндийн төв	179/2023	2 жил	2023.06.21	2025.06.21
19.	Хөвсгөл аймаг, Түнэл сумын эрүүл мэндийн төв	180/2023	3 жил	2023.06.24	2026.06.24
20.	Хөвсгөл аймаг, Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв	181/2023	2 жил	2023.06.24	2025.06.24